МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

“ШУТИС ПК-2030”

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙГ 2026-2030 ОНД ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ



Улаанбаатар хот

НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР ЖАГСААЛТ

№	Үгийн товчлол		Үгийн дэлгэрэнгүй тайлбар	
	Англи	Монгол	Англи	Монгол
1.	AI		Artificial Intelligence	Хиймэл оюун ухаан
2.	CLO		Course Learning Outcomes	Хичээл, сургалтын үр дүн
3.	HR	ХН	Human Resources	Хүний нөөц
4.	ICT	МХТ	Information and Communication Technology	Мэдээлэл Холбооны Технологи
5.	IT	МТ	Information Technology	Мэдээллийн Технологи
6.	KPI	ГТҮ	Key Performance Indicator	Гүйцэтгэлийн Түлхүүр Үзүүлэлт
7.	LMS		Learning Management System	Сургалт удирдах систем
8.	MNCEA	БМИҮЗ	Mongolian National Council for Education Accreditation	Монголын Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
9.	MUST	ШУТИС	Mongolian University of Science and Technology	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
10.	PI		Performance Indicator	Гүйцэтгэлийн үзүүлэлт
11.	R&D		Research and Development	Судалгаа ба хөгжүүлэлт
12.	SD		Strategic Directions	Стратеги чиглэл
13.	SO		Strengths & Opportunities	Давуу тал ба Боломж
14.	ST		Strengths & Threats	Давуу тал ба Аюул
15.	SWOT	СВОТ	Strengths, Weaknesses, Opportunities, Threats	Давуу тал, Сул тал, Боломж ба Аюул
16.	T&L	ЗАЗ	Teaching & Learning	Заах Арга Зүй
17.	TVET		Technical and Vocational Education and Training	Мэргэжлийн болон Техникийн Боловсрол, Сургалт
18.	WO		Weaknesses & Opportunities	Сул тал ба Боломж
19.	WT		Weaknesses & Threats	Сул тал ба Аюул
20.		ПК		Политехник коллеж

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ 4

ШУТИС-ийн харьяа Политехник коллежийн Удирдах зөвлөлийн хуралдааны тогтоол ... 5

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ 6

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТАЛСАН ЗАРЧИМ 6

Сургалтын чанар, чадамжид суурилсан хөгжил 13

Удирдлага, засаглал, чанарын баталгаажуулалт 13

ХОЁРДУГААР БҮЛЭГ 14

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ 14

ГУРАВДУГААР БҮЛЭГ 19

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙГ 2030 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ, ЗОРИЛГО 19

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ 20

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 20

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. СУРГАЛТЫН ЧАНАР, ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХӨГЖИЛ ... 20

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2 БАГШ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ, МАНЛАЙЛАЛ 23

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ СУРГАЛТЫН ОРЧИН, ДЭД БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ 27

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. АЖ ҮЙЛДВЭР, ДОТООД ГАДААДЫН ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН СУРГАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ 30

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ .. 33

ӨМНӨХ ҮГ



Дэлхийн эдийн засаг, техник технологийн хурдацтай хөгжил, хөдөлмөрийн зах зээлийн хувьсан өөрчлөгдөж өнөөгийн нийгэмд Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбар нь улс орны тогтвортой хөгжил, эдийн засгийн өрсөлдөх чадвар, хүний нөөцийн чадавхыг тодорхойлогч стратегийн тэргүүлэх чиглэл болж байна. Тэр дундаа дижитал шилжилт, хиймэл оюун ухаан, ногоон хөгжил, инновацад суурилсан эдийн засгийн шинэ орчин нь боловсролын тогтолцооноос зөвхөн мэдлэг эзэмшүүлэх бус, хөрвөх чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй, ёс зүйтэй, ур чадвартай, насан туршдаа суралцах чадамжтай мэргэжилтэн бэлтгэх шинэ бодлого, зорилт тавигдаж байна.

Энэхүү бодлогын хүрээнд МбТБС-ийн салбарын чанар, үр өгөөш, хүртээмжийг дээшлүүлэх, олон улсын стандарт, магадлан итгэмжлэлийн шаардлага, ажил олгогч болон түншлэгчийн уялдаа холбоог бүх шатанд оролцоог хангах, сургалтын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүн, сургалтын хосолмол орчныг бүрдүүлэх, өргөжүүлэх асуудал хөгжлийн тэргүүлэх чиглэл болж байна.

Иймд байгууллагын тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг хангах нь урт хугацааны бодлого, оновчтой стратеги төлөвлөлтөөс шууд хамаарах тул бид байгууллагынхаа өнөөгийн нөхцөл байдал, гадаад дотоод орчны шинжилгээнд тулгуурлан ШУТИС-ийн харьяа Политехник коллежийн стратеги төлөвлөгөөг “ШУТИС ПК-2030” боловсруулан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

“ШУТИС ПК-2030” стратеги төлөвлөгөө нь бидний ирээдүйн чиг баримжаа, хөгжлийн замналыг тодорхойлохын зэрэгцээ байгууллагын соёл, үнэт зүйл, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд чиглэн оюутан суралцагч, ажил олгогч, түншлэгч, хамтрагч байгууллага, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чанартай үйлчилгээ, үр дүнг бий болгохыг зорьж байна. Төлөвлөгөөг боловсруулахдаа салбарын хууль, эрх зүйн орчин, улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, оролцогч талуудын санал бодлыг өргөнөөр тусгасан болно.

Бид энэхүү стратегийг хэрэгжүүлснээр үйл ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэн, хамтын ажиллагаа, инновац, хариуцлагатай менежментийг эрхэмлэн ажиллаж, нийгэмд үзүүлэх эерэг нөлөөллөө нэмэгдүүлж, байгууллагын хөгжлийн дараагийн шатанд итгэл төгс алхах болно.

ШУТИС-ийн харьяа Политехник коллежийн захирал Б.Сүхбат

ШУТИС-ийн харьяа Политехник коллежийн Удирдах зөвлөлийн хуралдааны тогтоол

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 25 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

"ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-г
батлах тухай

Монгол улсын Боловсролын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6.1, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 216-р тогтоол, ШУТИС-ийн харьяа ПК-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.2 заалт, ШУТИС-ийн харьяа ПК-ийн Удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн харьяа ПК-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх "ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар батлалсугай.

2. "ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-г 2026 оноос эхлэн хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг ШУТИС-ийн харьяа ПК-ийн захирал /Б.Сүхбат/-д даалгасугай. Үүнд:

а. "ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-г сурталчлан таниулах ажлыг 2026 оны эхний хагас жилд коллежийн багш, ажилтан, оюутан суралцагч, ажил олгогч, түншлэгч байгууллагуудад зохион байгуулах;

б. "ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхтэй холбоотой зардал, үндэслэлийг боловсруулж, жил бүрийн үйл ажиллагааны төсөвт тусгуулан Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн, батлуулах;

в. "ШУТИС ПК-2030 стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг үе шат бүрээр дүгнэн Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэх;

ДАРГА Т.НАМНАН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНДЭСЛЭЛ, БАРИМТАЛСАН ЗАРЧИМ

Политехник коллеж нь аж үйлдвэр, хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээнд тулгуурласан, ажил олгогч, түншлэгчийн оролцоотой үйлдвэрлэл–сургалтын нягт уялдаатай, суралцагч нэг мэргэжлээр хязгаарлагдахгүй инженер, техник, мэдээлэл технологи, үйлдвэрлэл, үйлчилгээний огтлолцолд шаардагдах өргөн хүрээний ур чадварыг эзэмшүүлэх зорилготой сургалтын байгууллага болон хөгжиж байна..
Тус коллеж нь чадамжид суурилсан, шаталсан, нэгдмэл агуулгатай уян хатан хөтөлбөрийг хэрэгжүүлэн бодит ажлын байранд шууд ажиллах, асуудал шийдвэрлэх, тасралтгүй суралцах чадварыг төлөвшүүлэхэд чиглэн, дижитал болон ногоон шилжилтийн хүрээнд автоматжуулалт, ухаалаг үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүч зэрэг ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн ур чадварыг цогцоор нь олгох сургалтын хөтөлбөрийг хөгжүүлж байна.
Цаашид бид төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчдын сэтгэл ханамж, нийгэм–эдийн засагт үзүүлж буй бодит нөлөөгөөр хэмжигдэх, байгууллагын удирдлага, засаглал нь өгөгдөл, шалгуур үзүүлэлтэд суурилсан ил тод, хариуцлагатай тогтолцоонд шилжин хүний нөөцийн стратегийн төв болон төлөвшиж байна.
ШУТИС-ийн харьяа Политехник коллежийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Дунд хугацааны зорилтот хөтөлбөр “Шинэ сэргэлтийн бодлого”, дэлхий нийтийн сайн сайхны төлөөх “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөр, 14 мега төсөл, ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө, Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц зэрэг баримт бичгийн үзэл санаа, дэвшүүлсэн зорилттой уялдуулан боловсруулав.
УИХ-аас баталсан боловсролын багц хууль болон мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчлэлийн агуулга, зорилго, зарчим, боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө болон боловсролын асуудал эрхэлсэн яамны бодлого, үйл ажиллагаанд онцлон тусгасан улсын хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн боловсрол олгох, олон нийтэд хандсан нээлттэй боловсрол, насан туршийн суралцахуй, цахим сургалтыг дэмжих, улсдаа төдийгүй дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтэн бэлтгэх зорилт, үйл ажиллагааг стратеги төлөвлөгөө боловсруулахад чухалчлан үзсэн болно.

Стратегийн төлөвлөгөөг боловсруулахад баримталсан зарчмууд

Төлөвлөлтийн үйл явц ил тод, нээлттэй байх зарчим: Төлөвлөлтийн үйл явц сургуулийн оролцогч талуудад ил тод байх, мэдээлэл солилцох урсгал нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлсэн.

Талуудын оролцоог бүрэн хангах зарчим: Багш, ажилтан, суралцагч, ахмад багш, ажилтан, төгсөгч, ажил олгогч, бодлого боловсруулагч зэрэг талуудын оролцоог бүрэн хангахыг зорив.

Нөхцөл байдал, суурь түвшний үнэлгээ бодитой байх зарчим: Сургуулийн өнөөгийн нөхцөл байдал, хүрсэн суурь түвшнийг бодитойгоор үнэлж, судалгаа шинжилгээний үр дүн, баримтад үндэслэн дүгнэлт гаргахыг чухалчлав.

Төлөвлөлтийн SMART зарчим:

- *Тодорхой (Specific): Стратегийн зорилго нь тодорхой, ойлгомжтой байх;*
- *Хэмжигдэхүйц (Measurable): Стратегийн зорилго бүрийг бодитойгоор хэмжих боломжтой үзүүлэлтийг тодорхойлох;*
- *Хүрч болохуйц (Achievable): Стратегийн зорилго бодитой, хүрч болохуйц байх;*
- *Бодит (Realistic): Стратегийн зорилго нь байгууллагын өнөөгийн чадамж, нөөц бололцоотой нийцэж, хэрэгжихүйц байх;*
- *Хугацаатай (Timebound): Зорилт тодорхой хугацаатай, хэрэгжилтийг дүгнэх зарчмыг бариптлав*

Аж үйлдвэрийн 4 ба 5 дахь хувьсгалын өөрчлөлт, улс хоорондох ажиллах хүчний шилжилт, залуу үеийн ажил мэргэжлийн сонирхол, Монгол Улсын хүн амын өсөлт, хөдөлмөрийн оролцоо, хөдөлмөрийн бүтээмжийг тасралтгүй дээшлүүлэх шаардлага зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлийн улмаас өрсөлдөх давуу тал, стратегийг тодорхойлох шаардлага үүсээд байна.

- Нийгмийн талаас, “шинэ мэдлэг, дижитал хэрэглээ”-ний түвшнийг ахиулах;
- Улс төрийн талаас, дэлхийн боловсролын зах зээлд хандах хандлагыг харгалзах;
- Технологийн талаас, салбаруудын харилцаа хамаарал, ач холбогдлыг уялдуулах, блокчейн, хиймэл оюун ухаан, AR/VR гэх мэт хэрэгслийн ухаалаг хэрэглээ рүү шилжих;
- Эдийн засаг талаас, Азийн орнуудын эдийн засгийн өсөлт хөгжил, бүс нутгийн интеграцид нэгдэх;
- Байгаль орчин талаас, ирээдүйд нүүрс хүчлийн хийн хэмжээг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг стратегийн байр суурьтай болох шаардлагатай юм.

Иймд салбар дундын судалгааг хамтарч хийх, дотоод болон гадаад санхүүжилтээр дэмжих, өрсөлдөөнд өөрийн байр суурийг тогтвортой байлгах, эрсдэл, боломжийг үнэлэх, амжилтын гол хүчин зүйлст тулгуурлах, боловсролын үйлчилгээний өвөрмөц үнэ цэнийг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн хөгжлийн боломжийг харгалзаж үзэх шаардлагатай.

Судалгааны арга зүй


ШУТИС-ийн харьяа Политехник коллежийн (ПК) урт хугацааны хөгжлийн төлөвлөлтийг хийхдээ дараах зурагт үзүүлсэн загвар аргачлалыг ашигласан. Энэ нь архитектур буюу бүтцийн, оролцооны, стратеги тогтолцооны гэсэн 3 загвараас бүрдэнэ.



1.1. Төлөвлөлтийн архитектур загвар

Архитектур загварыг барилга байгууламжтай зүйрлэж болох бөгөөд ерөнхий төлөвлөлтийн гол элементүүд болох алсын хараа, зорилго, стратеги, гүйцэтгэлийг тодорхойлохдоо энэ загварыг ашигладаг. Өөрөөр хэлбэл яг л барилга байгууламжийн хэмжээ, үнэ өртөг, цонхны тоо, байршил зэрэг шаардлагыг тодорхойлдогтой ижил гэсэн үг юм.

Архитектур загварыг мастер төлөвлөгөө боловсруулахад ашигласнаар зорьсон зорилгодоо хүрэх зам, эцсийн үр дүнг тодорхой харуулахаас гадна давхардсан хөрөнгө оруулалт, шаардлагагүй үйл ажиллагаанаас зайлсхийх, мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед түүний гүйцэтгэлийг хамгийн дээд түвшинд хүргэх боломжийг бүрдүүлдэг.



1.2. Оролцооны загвар

Оролцооны загвар гэдэг нь аливаа асуудлыг шийдвэрлэх, инновац бий болгох ажлыг хариуцаж буй хүн өөрийн ажлын үр дүнд шууд хамааралтай бусад хүмүүсийг татан оролцуулах хэлбэр юм. Ингэж бусад хүмүүсийн оролцоог дэмжиж, нэгтгэн ажиллуулснаар хамгийн оновчтой шийдэл гарах эсэхийг баталгаажуулахгүй хэдий ч тэдний оролцоотой тодорхой сайжруулалт хийснээр
төлөвлөлтийг хамт олон хүлээн зөвшөөрөх, цаашлаад хэрэгжүүлэлтийн шатанд дэмжлэг үзүүлэх боломж бүрддэг.
Мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд гол оролцогч талуудыг хамруулсан уулзалт, семинар, хэлэлцүүлгүүдийг хэд хэдэн удаа амжилттай зохион байгуулсан болно. Ингэж мастер төлөвлөгөө боловсруулахад гол оролцогч талуудыг хамруулах нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад оролцогчдын манлайллыг бий болгох, оролцоог нэмэгдүүлэх үр дүнтэй ажил болдог юм.




1.3. Стратегийн хүрээний загвар

ШУТИС ПК-ийн 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа дараах гурван хэсэг бүхий стратегийн хүрээний загварыг ашигласан. Үүнд:

1) Стратегийн дүн шинжилгээ;
2) Стратегийн томьёолол;
3) Стратегийн хэрэгжүүлэлт.

Зурагт үзүүлснээр стратегийн хүрээний эдгээр гурван хэсэг нь өөр хоорондоо динамик байдлаар холбогдсон байна. Өөрөө хэлбэл тухайн хэсгийн үйл явцын үр дүн нь дараагийн хэсгийн үйл явцын оролт болно.
Зурагт үзүүлсэн дугаарын дагуу мастер төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны дараалал тодорхойлогдоно.



1.4. Зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Үйл ажиллагааны төлөвлөгөө гэдэг нь тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хийх ёстой алхмууд эсвэл үйл ажиллагааг шалгах хуудас бөгөөд стратеги төлөвлөлтийн чухал хэсэг болдог.

“As-Is” дүн шинжилгээ болон ПК-д тулгарч буй гол асуудлуудыг судалсны үндсэн дээр гол зорилтыг хэрэгжүүлэх “To Be” загвар болон нарийвчилсан төлөвлөгөөг санал болгосон.


Хяналт-шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээнд хэрэглэх арга, индикатор үзүүлэлтүүдийг мөн санал болгосон байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Одоогийн нөхцөл байдлын дүрслэл болон ирээдүйд хэрэгжүүлэх зорилго (байгаа/бий болох)
- Зорилгодоо хүрэхийн тулд хэрэгжүүлэх шаардлагатай стратегийн үйл ажиллагаа
- Зорилт тус бүрийг хариуцах хүмүүс
- Эдгээр зорилтууд хэзээ хэрэгжсэн байх(эцсийн хугацаа болон чухал үе шатууд)
- Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцүүд(төсөв гэх мэт)
- Ахиц дэвшлийг үнэлэх хэмжүүрүүд (гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд)

1.5. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө:

Мэргэжлийн болон техникийн боловсролын дотоод болон гадаад орчин өөрчлөгдөж байгаа учраас ПК-ийн шинэ хөгжлийн төлөвлөгөөг зайлшгүй боловсруулах шаардлагатай байна. Ингэхдээ 2030 он гэхэд дэлхийн шилдэг 1000 их сургуулийн нэг болох зорилт дэвшүүлсэн “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн ПК-ийн хөгжлийн шинэ, хэтийн төлөвлөгөөг (стратеги төлөвлөгөө) боловсруулах шаардлагатай болсон.



1.6. SWOT шинжилгээ

SWOT шинжилгээ нь тухайн байгууллагын дотоод, гадаад орчныг шинжлэн давуу болон сул талыг тодорхойлж, боломж, аюул заналын хүчин зүйлсийг тооцоолон, эдгээрт тулгуурлан удирдлагын стратегийг бий болгодог арга юм. SWOT шинжилгээний хамгийн том давуу тал нь байгууллагын дотоод болон гадаад орчны өөрчлөлтийг нэгэн зэрэг тодорхойлж ерөнхий дүн шинжилгээ хийх арга учраас стратеги төлөвлөгөөг боловсруулах эхний үе шатанд маш их хэрэгтэй байдаг.
SWOT шинжилгээний асуултууд: Сургуулийн дотоод болон гадаад орчны давуу тал, сул тал, боломж, аюул заналыг тодорхойлохын тулд дараах хүснэгтэд байгаа асуумжуудад хариулт авсан.

Давуу тал	Сул тал
• ПК нь ямар давуу талтай вэ? • ПК нь юуг сайн хийдэг вэ? • ПК -ийн амжилтын үндэс нь юу вэ? • Бусад коллежууд болон ПК-ийн давуу талыг юу гэж үздэг вэ?	• ПК-ийн юуг сайжруулах ёстой вэ? • ПК юуг муу хийдэг вэ? • ПК юунаас зайлсхийх ёстой вэ?
Боломж	**Аюул занал**
• ПК-д бий болсон сайн туршлагууд юу байна вэ? • ПК сайн орчныг хэрхэн бий болгосон бэ?	• ПК-д ямар саад бэрхшээл тулгардаг вэ? • ПК-ийн өрсөлдөгчдийн давуу тал вэ? • Боловсролын орчин өөрчлөгдөж байгаа нь ПК-ийн байр суурьт нөлөөлж байна уу? • ПК санхүүгийн хувьд асуудалтай юу? • Сургуулийн сул талууд нь сургалтын үйл ажиллагаанд ноцтой аюул учруулж болох уу?

Дараах дөрвөн чиглэлээр стратегийг гаргах хэрэгтэй. Үүнд:

1) SO стратеги: Давуу тал + Боломж
   ✓ Давуу талаа хэрэглэн боломжуудыг ашиглах стратеги
2) ST стратеги: Давуу тал + Аюул
   ✓ Давуу талыг ашиглан аюул заналыг даван туулах стратеги
3) WO стратеги: Сул тал + Боломж
   ✓ Боломжуудыг ашиглан сул талаа хяналтдаа байлгах стратеги
4) WT стратеги: Сул тал + аюул занал
   ✓ Сул талаа хяналтдаа авснаар аюул заналаас зайлсхийх стратеги

1.7. SWOT шинжилгээний үр дүн

2. SWOT шинжилгээний үр дүнг стратегийн 5 чиглэлээр гаргасан.


Шинжилгээний төлөв (стратегийн нөхцөл байдлыг үнэлэх)	SWOT ангилал	Стратеги чиглэлүүд	Зорилго бүрийн стратеги	
(S) Давуу тал **(W) Сул тал** **(O) Боломж** **(T) Аюул**	Боловсролын чадамж	Сургалтын чанар, чадамжид суурилсан хөгжил	SO	WO
			ST	WT
	Хүний нөөцийн чадамж	Багш, хүний нөөцийн чадавх, манлайлал	SO	WO
			ST	WT
	Дэд бүтэц, орчин	Суралцагч төвтэй сургалтын орчин, дэд бүтцийн шинэчлэл	SO	WO
			ST	WT
	Хамтын ажиллагаа	Аж үйлдвэр, дотоод гадаадын түншлэлд суурилсан сургалт, хөдөлмөр эрхлэлт	SO	WO
			ST	WT
	Засаглал, чанарын баталгаажуулалт	Удирдлага, засаглал, чанарын баталгаажуулалт	SO	WO
			ST	WT

Стратегийн нөхцөл байдлыг үнэлэх 5 чиглэл

Зорилтуудыг тодорхойлсон үр дүн

Зааг ялгааг тодорхойлох (GAP) шинжилгээ

Стратегийг хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлохын тулд зааг ялгааг тодорхойлох (GAP) шинжилгээг хийсэн. Энэ шинжилгээгээр одоогийн нөхцөл байдлыг ирээдүйн зорилтот нөхцөлүүдтэй харьцуулан дутагдал, сайжруулах боломжуудыг тодруулдаг.



GAP шинжилгээ

Зорилтуудыг дараах алхмуудын дагуу тодорхойлсон. Үүнд:

1. Дүн шинжилгээний цар хүрээ болон зорилгуудаа тодорхойлох.
2. Ирээдүйн төлөв байдлыг тодорхойлох

3. Одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх
4. Одоогийн төлөв байдлыг ирээдүйн төлөвтэй харьцуулах

5. Зааг ялгааг гарган зөрүүг тогтоох
6. Зөрүүг арилгах зорилтуудыг тодорхойлох.



Зорилтуудыг тодорхойлох загвар

Дээрх загварыг ашиглан стратеги бүрийг хэрэгжүүлэх зорилтуудыг тодорхойлсон болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн Газраас 2023 оны 306 тогтоол гарч Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Механик тээврийн сургуулийн Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Ой модны сургалт, судалгааны дэргэдэх Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Монгол Улсын их сургуулийн Худалдааны сургуулийн Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг нэгтгэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Политехник коллеж болгон 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа хууль дүрмийн хүрээнд явуулж байна.

Нэгтгэгдсэн сургуулиудыг товч дурдвал:

ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Тус сургууль Сайд нарын зөвлөлийн 1969 оны 3-р сарын 31-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Улаанбаатар хотод ЗХУ-ын техник, эдийн засаг, мэргэжилтний буцалтгүй тусламжаар Тээврийн Яамны харьяа “Учебный центр металлистов” нэртэй, иж бүрэн тоноглогдсон техник мэргэжлийн сургууль ашиглалтад орж 1969-1970 оны хичээлийн жилээс сургалт хүмүүжлийн ажлаа явуулж эх орондоо мэргэжилтэй ажилчдыг бэлтгэж эхэлсэн.

Тус Техник мэргэжлийн сургууль нь 600 хүүхдийг үндсэн зургаан мэргэжлээр болон түр сургалтаар сургах зориулалттай нарийн мэргэжлийн дадлагын газар, лаборатори, автомашины граж бүхий хичээлийн байр, 420 хүүхдийн багтаамжтай оюутан, суралцагчдын дотуур байр, жолооны 5 машин, аж ахуйн ба үйлчилгээнд зориулсан автобус зэрэг бүгд 7 автомашинтайгаар Зөвлөлтийн 12 мэргэжилтэн

манай 70 гаруй багш, ажилтантай 500 хүүхдийн элсэлттэйгээр нээлтээ хийж анхны хичээлээ эхэлжээ.

1992 онд тээврийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд нэгдэн тус ТМС–ийн сургалтын бааз дээр түшиглэн ШУТИС–ийн бүрэлдэхүүнд Тээврийн сургуулийг байгуулж тус Техник мэргэжлийн сургууль татан буугдсан боловч БСШУ–ны сайдын 2005 оны 401 тоот тушаал, ШУТИС–ийн ректорын 2006 оны 118 тоот тушаалаар Механик Инженерийн Сургуулийн бүрэлдэхүүнд Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв шинэчлэгдэн байгуулагдсан байна.

Нийт 23 багш, ажилтантай. захирал, нягтлан бодогч, сургалтын албаны дарга, сургалтын албаны ажилтан, нийгмийн ажилтан, үйлчилгээний 4 ажилтан, 14 багштай. Багш нарын 86 хувь нь магистрын зэрэгтэй, боловсролын салбарын тэргүүний ажилтан 10, хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан 8, зөвлөх багш 2, тэргүүлэх багш 3, заах арга зүйч багш 10, Австрали Улсын олон улсын сургалтын байгууллага Итас группийн “Диплом”, “Сургалт ба үнэлгээ”–IV сертификаттай багш нар ажиллаж байсан.

Тус сургууль нь ШУТИС-ийн VII байранд 330 суудалтай хичээлийн 7 кабинет, 20 компьютер бүхий 1 лаборатори, хүнд машин механизмын, автомашины засварын, гагнуурын, токарь-фрезерийн зориулалтын 4 дадлагын газартай.

Сургалтын чиглэл:

Мэргэжлийн боловсролын сургалт

- Хүнд машин механизмын оператор 1 жил
- Хүнд машин механизмын засварчин 2,5 жил
- Автомашины засварчин 2,5 жил
- Гагнуурчин 1 жил, 2,5 жил
- Метал боловсруулах суурь машины оператор 2,5 жил
- Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмжийн механик 1 жил

Түншлэлийн хүрээнд нийт 63 аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллаж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 75 хувьтай. МСҮТ байгуулагдсанаас хойш сургалтын чиглэлээр 4000 гаруй мэргэжилтэн бэлтгэжээ.

ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2008 оны 281 тоот тушаалаар ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн Технологийн Сургуулийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулагдаж 2008 оноос мэргэжлийн боловсролын сургалтыг нийт 5 мэргэжлээр зохион байгуулж хөдөлмөрийн зах зээлд 1000 орчим мэргэжилтэн бэлтгэн нийлүүлсэн байна. МСҮТ нь төвийн захирал, нягтлан бодогч, сургалтын менежер, мэргэжлийн багш 4, үйлчилгээний ажилтан 2 нийт 9 хүний орон тоотой. Ерөнхий эрдмийн гэрээт багш 10 орчим ажилладаг. Нийт багш ажилтны 80% бакалавр, магистрын зэрэгтэй, мэргэжлээрээ ААНБ-д ажиллах олон жилийн туршлагатай.

Тус сургууль нь ШУТИС-ийн хичээлийн 11 дүгээр байранд 410 м2 онолын танхим, 400 орчим м2 дадлагын газар багш ажилтнуудыг өрөө 200 м2 талбайг эзэмшин үйл ажиллагаа явуулдаг.

Ойжуулалтын дадлагын полигон Төв аймгийн Батсүмбэр суманд 2 га талбайг хичээлийн дадлагад ашигладаг. Түншлэлийн хүрээнд хамтран ажилладаг ой, мод боловсруулах салбарын байнгын түнш 80 байгууллагатай хамтран ажилладаг бөгөөд төгсөгчдийн 75-80% ажлын байраар хангагдаж нийт 1800 гаруй мэргэжилтэн бэлтгэжээ.

Сургалтын чиглэл:

Мэргэжлийн боловсролын сургалт

- Нарийн мужаан 2,5 жил

- Мод боловсруулах төхөөрөмжийн засварчин 2,5 жил
- Модон эдлэлийн мужаан 1 жил
- Ойжуулагч 1 жил
- Барилга угсралтын мужаан 1 жил

МУИС-ийн Худалдааны сургуулийн Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв

МСҮТ нь анх 1969 онд Худалдааны техник мэргэжлийн сургууль нэртэй байгуулагдан эдүгээ 40 дэх жилдээ сургалт, үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд энэ хугацаанд тогооч, нарийн боовчин, худалдагч, касс, нярав, нарийн бичгийн дарга, бараа түүхий эдийн брокер, зөөгч бармен худалдаа нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засварчин гэх мэт мэргэжлээр 11000 шахам мэргэшсэн ажилтан бэлтгэсний 90 гаруй хувь нь худалдаа, хоол үйлчилгээний чиглэлээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг бизнесийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд амжилттай ажиллаж байгаагаас Монгол улсын мастер тогооч нарын 76%, улсын аварга тогооч, худалдагч нарын 80 гаруй хувь нь манай төгсөгчид байна.
Сургалтын чиглэл:
Мэргэжлийн боловсролын сургалт

- Худалдааны газрын үндсэн ажилтан
- Хоол үйлдвэрлэлийн технологи
- Зоогийн газрын зохион байгуулагч
- Компьютерын операторч - албан хэргийн ажилтан
- Худалдаа нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засварчин

ШУТИС-ийн Политехник коллеж нь ШУТИС-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөр, багшлах хүний нөөц, чадавх, дадлага лабораторийн орчинд суурилан шаталсан сургалтын тогтолцоотой мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага юм.

Алсын хараа (Vision)
Сургалтын чанар, орчин, түншлэл, засаглалаараа үндэсний хэмжээний жишиг политехник коллеж болно.

Эрхэм зорилго (Mission)
Суралцагч бүрийг чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай сургалтын хөтөлбөрөөр өнөөдөр ажиллах, маргааш дэвших ур чадвартай мэргэжилтэн болгон төлөвшүүлнэ.

Бүтэц, орон тоо
Нийт 49 үндсэн багш, ажилтантай, тэнхимийн зохион байгуулалттай. Нийт багш, ажилтны 34,7% нь мэргэшүүлэх хичээлийн, 26,5% нь ерөнхий эрдмийн хичээлийн багш, 38,8% нь захиргаа аж ахуй ажилтан байна. Багш нарын 2.04% нь доктор, 76,6% нь магистр, 33,3% нь бакалаврын боловсролын зэрэгтэй. Мөн 3,3% нь мэргэшсэн инженер, 6,6% нь зөвлөх инженер, 16,6% нь тэргүүлэх, 36,6% нь арга зүйч мэргэжлийн зэрэгтэй.

Сургалтын хөтөлбөр
Техникийн боловсрол олгох – /суралцах хугацаа 1,5 жил/

- ✓ Уурхайн машин механизмын ашиглалт
- ✓ Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ
- ✓ Өрөмдлөгийн машин, тоног төхөөрөмжийн ашиглалт

- ✓ Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт
- ✓ Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн завсар, үйлчилгээ

Мэргэжил олгох – /суралцах хугацаа 1 жил/

- ✓ Уул уурхайн ашиглалт
- ✓ Хоолны үйлчилгээ
- ✓ Гагнуурчин
- ✓ Механик
- ✓ Ойн аж ахуй, ойжуулагч
- ✓ Барилга бүтээц, угсралт

Мэргэжлийн боловсрол олгох – /суралцах хугацаа 3 жил/

- ✓ Уул уурхайн машин механизмын угсралт засвар, үйлчилгээ
- ✓ Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ
- ✓ Хоолны үйлчилгээ
- ✓ Гагнуурчин
- ✓ Барилга бүтээц, угсралт
- ✓ Цахилгаан хангамж, тоног төхөөрөмж ашиглалт
- ✓ Мэдээллийн технологи, техник хангамж

Хөтөлбөрийн хүрээнд 2026 оны хаврын улиралд 1003 суралцагч суралцаж байна. Үүний 8.4% нь эмэгтэй суралцагч, 91.6% нь эрэгтэй суралцагч, 31,7% нь насанд хүрсэн суралцагч байна.

Сургалтын орчин

Нийт 500 суудалтай хичээлийн байр, Уурхайн машин механизм, угсралт засвар үйлчилгээ, Гагнуур, Механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ, Барилга бүтээц, угсралт, Хоолны үйлчилгээ мэргэжлийн дадлагын газрууд болон Компьютерын лаборатори, уншлагын танхим, биеийн тамирын заалтайгаар сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.









Д л

Дотоод хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны байдлаар барилга, боловсруулах үйлдвэрлэл, машины механизмын засвар үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ, уул уурхайн олборлолт, хөдөө аж ахуй, ойн аж ахуй чиглэлийн 115 аж ахуйн нэгж, хувь хүнтэй суралцагчдыг үйлдвэрлэлийн дадлага сургалтанд хамруулах, төгсөгчдийг ажилд зуучлах, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Хүнд Аж үйлдвэрийн "Baotou Light Industry Vocational Technical" коллеж, Япон улсын Үндэсний Техникийн Их сургууль Югэ коллежтэй багшийн мэргэжил дээшлүүлэх, оюутан-суралцагч солилцооны хөтөлбөрийн хүрээнд суралцагчдыг үйлдвэрлэлийн дадлагад явуулах чиглэлээр хамтран ажилладаг.













ГУРАВДУГААР БҮЛЭГ

ШУТИС-ИЙН ХАРЬЯА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙГ 2030 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ, ЗОРИЛГО

Алсын хараа (Vision)

Сургалтын чанар, орчин, түншлэл, засаглалаараа үндэсний хэмжээний жишиг политехник коллеж болно.

Эрхэм зорилго (Mission)

Суралцагч бүрийг чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай сургалтын хөтөлбөрөөр өнөөдөр ажиллах, маргааш дэвших ур чадвартай мэргэжилтэн болгон төлөвшүүлнэ.

Стратегийн тэргүүлэх чиглэл

Алсын хараа, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн тэргүүлэх таван чиглэлийг тодорхойллоо. Үүнд:

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. СУРГАЛТЫН ЧАНАР, ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХӨГЖИЛ – Чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай салбар дундын хөтөлбөрүүдийг хөгжүүлэн суралцагчийн бодит ур чадварыг үнэлэх тогтолцоог сайжруулна.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2. БАГШ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ, МАНЛАЙЛАЛ- Үйлдвэрлэлд суурилсан, мэргэшсэн багш нарын багийг бүрдүүлэн тасралтгүй хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх, салбарын мэргэжилтэн, инженерийг сургалтад татан оролцуулна.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ СУРГАЛТЫН ОРЧИН, ДЭД БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ- Олон зориулалттай, орчин үеийн лаборатори, дадлагын баазыг хөгжүүлэх, дижитал болон виртуал сургалтын орчныг өргөжүүлэн, аюулгүй, хүртээмжтэй, суралцахад ээлтэй орчин бүрдүүлнэ.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. АЖ ҮЙЛДВЭР, ДОТООД, ГАДААДЫН ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН СУРГАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ- Ажил олгогчийн оролцоотой хөтөлбөр, дадлагын тогтолцоог хөгжүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих механизм бүрдүүлэх, Үйлдвэрлэл–сургалт–ажлын байрны уялдааг хангана.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ- Өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг сайжруулах, ил тод, хариуцлагатай, үр ашигтай засаглалыг төлөвшүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС:

Суралцагч төвтэй байдал - Суралцагч бүрийг хөгжлийн төв болгон ур чадвартай, мэргэжилтэн болгон төлөвшүүлнэ.

Чадамж ба чанар - Сургалтын бүх үйл ажиллагаанд ур чадвар, чанарын баталгааг нэн тэргүүнд тавьж, тасралтгүй сайжруулна.

Хөдөлмөрийн зах зээлд нийцэх байдал - Аж үйлдвэр, ажил олгогчийн оролцоонд тулгуурлан сургалтын агуулга, орчныг хөгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг бодит үр дүнгээр хангана.

Хамтын ажиллагаа, түншлэл - Багш, суралцагч, ажил олгогч, түнш байгууллагуудтай нээлттэй, харилцан ашигтай, тогтвортой хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

Ёс зүй, хариуцлага - Ил тод, шударга, хариуцлагатай үйл ажиллагааг баримталж, боловсролын байгууллагын ёс зүй, соёлыг төлөвшүүлнэ.

Уриа үг: Чадвараар бүтээнэ

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

СТРАТЕГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ, ЗОРИЛГО, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 1. СУРГАЛТЫН ЧАНАР, ЧАДАМЖИД СУУРИЛСАН ХӨГЖИЛ

Чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай салбар дундын хөтөлбөрүүдийг хөгжүүлэн суралцагчийн бодит ур чадварыг үнэлэх тогтолцоог сайжруулах

Зорилт 1.1. Чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэх

Политехник коллежийн сургалтын хөтөлбөрийг уламжлалт мэдлэг төвтэй загвараас чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий ажлын байранд шаардагдах ур чадварт чиглэсэн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлнэ. Хөтөлбөр нь чадамжийн нэгжид суурилсан, модульчлагдсан бүтэцтэй байж, суралцагчийн хэрэгцээ, суурь мэдлэг, өмнөх туршлагыг харгалзан уян хатан суралцах боломж бүрдүүлнэ. Хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлт, эрэлт хэрэгцээтэй тогтмол уялдуулан шинэчилж, тасралтгүй сайжруулна.

Хэрэгжүүлэх стратеги

- Чадамжийн нэгжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай, модульчлагдсан хөтөлбөр хэрэгжүүлэх
- Суралцагчийн хэрэгцээ, туршлагад тулгуурласан суралцах боломж бүрдүүлэх
- Хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээл, аж үйлдвэрийн эрэлттэй тогтмол уялдуулан шинэчлэх

Зорилт 1.2. Шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай салбар дундын сургалтын хөтөлбөрийг бий болгох

Сургалтын тогтолцоог шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай салбар дундын бүтэцтэй болгон хөгжүүлж, суралцагчийг нэг мэргэжлээр хязгаарлагдах бус хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, дэвших, хөрвөх чадвартай мэргэжилтэн болгон бэлтгэнэ. Хөтөлбөр нь богино–дунд–ахисан түвшний залгамж холбоог хангаж, ерөнхий суурь ур чадвар, салбарын болон дэмжих ур чадварыг интеграцчилсан цогц бүтэцтэй байна.

Хэрэгжүүлэх стратеги

- Богино, дунд, ахисан түвшний сургалтын залгамж холбоог хангах
- Мэргэжил хооронд хөрвөх боломжийг нээх
- Ерөнхий + салбарын + дэмжих ур чадварыг бүх хөтөлбөрт интеграцчилах

Зорилт 1.3. Сургалтын арга зүйг бодит гүйцэтгэлд суурилсан болгох

Сургалтыг онол төвтэй хэлбэрээс дадлага, төсөл, үр дүнд суурилсан арга зүйд бүрэн шилжүүлнэ. Суралцагч бодит ажлын орчинд ойролцоо нөхцөлд ур чадвараа эзэмшиж, үйлдвэрлэлд шууд ажиллах чадамжтай төгсөх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ дижитал, симуляц, виртуал орчныг ашиглан сургалтын үр нөлөөг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

- Дадлага, төсөл, бодит асуудалд суурилсан сургалтыг нэмэгдүүлэх
- Үйлдвэрлэл, байгууллагад суурилсан дадлагын сургалтыг өргөжүүлэх
- Дижитал/симуляц/виртуал орчны хэрэглээг үе шаттай нэвтрүүлэх

Зорилт 1.4. Суралцагчийн бодит ур чадварыг үнэлэх тогтолцоог сайжруулах

Суралцагчийн мэдлэгийг зөвхөн онолын шалгалтаар бус, бодит гүйцэтгэл, чадварын илрэлээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлнэ. Үнэлгээ нь гүйцэтгэлд суурилсан, бодит даалгавар/төсөлд тулгуурласан, ажил олгогчийн оролцоотой, ил тод, шударга, баталгаатай хэрэгжинэ.

Хэрэгжүүлэх стратеги

- Гүйцэтгэлд суурилсан, бодит даалгаврын үнэлгээг нэвтрүүлэх
- Ажил олгогчийн оролцоотой үнэлгээний механизмыг хөгжүүлэх
- Үнэлгээний ил тод, шударга, баталгаатай байдлыг хангах

2030 он хүртэл хүрэх түвшин

Үзүүлэлт, KPI	2030 хүрэх түвшин
Шаталсан бүтэц бүхий чадамжид суурилсан хөтөлбөрийн эзлэх хувь	100%
Салбар дундын хөтөлбөрийг шинээр боловсруулах	3
Дадлага/төсөлд суурилсан хичээлийн эзлэх хувь	≥70%
Үйлдвэрлэлд суурилсан дадлага хийсэн суралцагчийн хувь	≥85%
Дижитал/виртуаль орчин ашигладаг хөтөлбөрийн хувь	≥60%
Гүйцэтгэлд суурилсан үнэлгээг нэвтрүүлсэн хичээлийн хувь	100%
Ажил олгогч оролцсон үнэлгээний тоо (жилд)	10+
Үнэлгээний ил тод байдалд сэтгэл ханамжтай суралцагчийн хувь	90%+
Төгсөгчдийн мэргэжлээрээ ажилласан хувь (6 сарын дотор)	90%+

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2025–2026 он

- Чадамжид суурилсан, хөтөлбөрийн жишиг загвар боловсруулах
- Шаталсан сургалтын загвар, салбар дундын модулиудыг тодорхойлох
- Дадлага/төсөлд суурилсан сургалтын загвар, удирдамж батлах
- Гүйцэтгэлд суурилсан үнэлгээний удирдамж, рубрик боловсруулах, бодит даалгаврын сан бүрдүүлэх

2027–2028 он

- Мэргэжил хооронд хавсран суралцах механизмыг хэрэгжүүлэх
- Бүх мэргэжилд гүйцэтгэлд суурилсан үнэлгээ нэвтрүүлэх, ажил олгогчийн үнэлгээг тогтмолжуулах
- Симуляц/виртуал сургалтын хэрэглээг нэмэгдүүлж, сургалтын үр нөлөөг сайжруулах
- Хөтөлбөрийн шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн судалгаатай уялдуулах

2029–2030 он

- Чадамжид суурилсан, шаталсан сургалтын тогтолцоог бүрэн тогтворжуулах
- Үнэлгээний ил тод, баталгаажуулалт (портфолио, нотолгоо)-ыг бүрэн хэрэгжүүлэх

- Сургалтын чанарын иж бүрэн үнэлгээ хийж, сайжруулалтын цикл хэрэгжүүлэх
- Ирээдүйн ур чадвар (дижитал/ногоон)-ыг бүх хөтөлбөрт бүрэн шингээх
- Сургалтын үр нөлөөг хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлттэй уялдуулан үнэлэх

Үнэлгээний шалгуур

1. Хөтөлбөрийн чадамжид суурилсан шаталсан сургалт бүхий нэгдмэл агуулгатай, модульчлал, шатлалын хэрэгжилт
2. Суралцагчийн бодит ур чадварын ахиц (дадлага/төсөл/гүйцэтгэлээр) дэвшил
3. Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, рубрик үнэлгээний хэрэгжилт, баримтжуулалт
4. Ажил олгогчийн оролцоо, төгсөгчийн “ажилд бэлэн” түвшин, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт
5. Суралцагчийн үнэлгээний ил тод байдалд өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ

Хэмжих аргачлал

1. Хөтөлбөрийн баримт бичгийн аудит
2. Суралцагчийн үнэлгээний тайлан, бүртгэл
3. Гүйцэтгэлд суурилсан үнэлгээний рубрик, шалгах хуудас, бодит даалгаврын сангийн тайлан
4. Үйлдвэрлэлийн дадлагын тайлан, ажил олгогчийн үнэлгээ, протокол
5. LMS/дижитал системийн өгөгдөл (ашиглалт, гүйцэтгэлийн нотолгоо)
6. Төгсөгч, ажил олгогчийн судалгаа; хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 2 БАГШ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХ, МАНЛАЙЛАЛ

Сургалтын чанар, үр нөлөөг тодорхойлогч үндсэн хүчин зүйлийн нэг бол багш, хүний нөөцийн чадавх, тэдний мэргэжлийн хөгжил, манлайлал юм. Сургалтын байгууллагын тогтвортой хөгжил нь онолын мэдлэгээс гадна практик орчинд суурилсан ур чадвар эзэмшсэн, тасралтгүй хөгжих чадвартай багштай шууд хамааралтай тул энэхүү чиглэлийг стратегийн тэргүүлэх чиглэл болгон тодорхойллоо.
Иймээс үйлдвэрлэлд суурилсан, мэргэшсэн багш нарыг салбарын хэрэгцээ, технологийн шинэчлэлтэй уялдуулан ажлын байрны дах туршлагад тулгуурласан сургалтаар дамжуулан багшийн мэргэжлийн чадамжийг тасралтгүй дээшлүүлэх мөн сургалтын агуулга, арга зүйг ур чадварт чиглүүлэх зорилгоор салбарын мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнуудыг сургалтад татан оролцуулах, зочин багш, ментор, дадлагын удирдагч зэрэг хэлбэрээр салбарын төлөөллийг сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцуулж, суралцагчдыг ажлын орчин, технологи, үйлдвэрлэлийн стандарттай танилцуулах, практик асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд анхаарна.

Хэрэгжүүлэх стратеги

Зорилт 2.1. Үйлдвэрлэлд суурилсан, мэргэшсэн багшийн багийг бүрдүүлэх

Сургалтын чанар, бодит үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор багш нарыг үйлдвэрлэлийн бодит орчинд суурилсан ур чадвартай, онол–практикийг хослуулан хөгжүүлнэ. Багшийн мэргэжлийн хөгжил нь салбарын технологи, ажлын байрны стандарт, бодит гүйцэтгэлд тулгуурласан байх зарчмыг баримтална.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Үйлдвэрлэлд суурилсан багшийн хөгжлийн тогтолцоо нэвтрүүлэх**
   - Багш нарыг үйлдвэр, аж ахуйн нэгжид тогтмол хугацаанд дадлагажуулах
   - Багшийн мэргэжлийн ур чадварыг ажлын байрны стандарттай уялдуулах
2. **Жишиг багшийн загвар хэрэгжүүлэх**
   - Онолын болон практик чадамжийг хослуулсан багшийн шалгуурыг тодорхойлох
   - Үйлдвэрлэл салбартай хамтарсан гэрээ, хөтөлбөр хэрэгжүүлэх
3. **Багшийн мэргэшил, үнэлгээний ил тод тогтолцоо бүрдүүлэх**
   - Үйлдвэрлэлд суурилсан гүйцэтгэлийн үнэлгээ нэвтрүүлэх
   - Чадамжийн ахицад суурилсан урамшууллын механизм бий болгох

Зорилт 2.2. Салбарын мэргэжилтэн, инженерийг сургалтад татан оролцуулах
Сургалтын агуулгыг бодит ажлын орчинд ойртуулах зорилгоор аж үйлдвэрийн салбарын туршлагатай мэргэжилтэн, инженер, техникийн ажилтныг сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцуулна. Ингэснээр суралцагчдын практик ур чадвар, асуудал шийдвэрлэх чадамжийг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Салбарын оролцоотой сургалтын загвар хөгжүүлэх**
   - Зочин багш, менторын тогтолцоо хэрэгжүүлэх
   - Үйлдвэрлэлд суурилсан кейс, бодит даалгаврын сургалт зохион байгуулах
2. **Ажил олгогч–сургалтын байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх**
   - Хичээл, дадлагын агуулгыг салбарын оролцоотойгоор хамтран боловсруулах
   - Дадлага, үйлдвэрлэлийн сургалтын удирдагчаар салбарын мэргэжилтнийг ажиллуулах
3. **Салбарын оролцооны тогтвортой механизмыг бүрдүүлэх**
   - Урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгуулах
   - Салбарын мэргэжилтний оролцоог үнэлэх, урамшуулах тогтолцоо бий болгох

Зорилт 2.3. Багш, хүний нөөцийн тасралтгүй хөгжлийн тогтолцоог бэхжүүлэх

Багш, хүний нөөцийг чадамжид суурилсан, шаталсан хөгжлийн тогтолцоонд хамруулж, тасралтгүй суралцах соёлыг байгууллагын түвшинд төлөвшүүлнэ. Сургалтын арга зүй, үнэлгээ, дижитал ур чадвар, инновац, үйлдвэрлэлийн шинэ технологийг системтэйгээр эзэмших боломжийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Чадамжид суурилсан багшийн хөгжлийн шаталсан загвар хэрэгжүүлэх**
   - Багшийн хөгжлийн түвшин, шаардлагыг тодорхойлох
   - Хөгжлийн замналыг төлөвлөх, үнэлэх систем нэвтрүүлэх
2. **Тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалтыг хөгжүүлэх**
   - Арга зүй, үнэлгээ, дижитал ур чадварын сургалтыг тогтмолжуулах
   - Сертификат, мэргэшүүлэх хөтөлбөрийг дэмжих
3. **Суралцахуйд суурилсан байгууллагын соёлыг төлөвшүүлэх**
   - Багш хоорондын туршлага солилцох, хамтын суралцах орчныг бүрдүүлэх
   - Инновац, шинэ санаачилгыг дэмжих

Зорилт 2.4. Манлайлал, менежментийн чадамжийг хөгжүүлэх

Сургалтын байгууллагын тогтвортой хөгжил, чанартай засаглалыг хангах зорилгоор удирдах ажилтан, ахлах багш нарын манлайлал, стратегийн сэтгэлгээ, менежментийн чадамжийг системтэйгээр хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Манлайллын чадамжид суурилсан хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх**
   - Удирдах ажилтны манлайлал, багийн удирдлагын сургалт зохион байгуулах
   - Өөрчлөлтийн менежмент, стратегийн төлөвлөлтийн чадамжийг нэмэгдүүлэх
2. **Залгамж халаа, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах**
   - Залгамж халааны бодлого, хөгжлийн замналыг тодорхойлох
   - Чадамжид суурилсан томилгоо, үнэлгээний тогтолцоо хэрэгжүүлэх
3. **Сайн засаглал, хариуцлагын соёлыг төлөвшүүлэх**
   - Ил тод, хариуцлагатай удирдлагын зарчим нэвтрүүлэх
   - Гүйцэтгэлд суурилсан удирдлагын тогтолцоог бэхжүүлэх

2030 он хүртэл хүрэх түвшин

Үзүүлэлт, KPI	2030 он хүртэл хүрэх түвшин
Үйлдвэрлэлд суурилсан дадлагад хамрагдсан багшийн хувь	80%+
Сургалтад оролцсон салбарын мэргэжилтэн, инженерийн тоо (жилд)	40+

Үзүүлэлт, KPI	2030 он хүртэл хүрэх түвшин
Зочин/хамтарсан багштай хичээлийн эзлэх хувь	50%+
Жилд багшийн хөгжлийн сургалтад хамрагдсан багшийн хувь	80%+
Сертификат, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан багшийн тоо	20+
Манлайлал, менежментийн сургалтад хамрагдсан удирдах ажилтны хувь	100%
Ажил олгогчийн багшийн ур чадварт өгсөн сэтгэл ханамж	90%+

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2025–2026 он

- Үйлдвэрлэлд суурилсан багшийн хөгжлийн бодлого, журам боловсруулах
- Багшийн үйлдвэрлэлийн дадлагын тогтолцоо нэвтрүүлэх
- Зочин багшийн эрх зүйн орчныг бүрдүүлэх
- Багшийн чадамж, манлайллын суурь үнэлгээ хийх

2027–2028 он

- Салбарын мэргэжилтэн, инженерийн оролцоотой сургалтыг өргөжүүлэх
- Багшийн тасралтгүй хөгжлийн шаталсан тогтолцоог хэрэгжүүлэх
- Удирдах ажилтны манлайлал, менежментийн сургалтыг тогтмолжуулах

2029–2030 он

- Багш, хүний нөөцийн хөгжлийн тогтолцоог тогтворжуулах
- Салбарын оролцоотой сургалтын чанарын иж бүрэн үнэлгээ хийх
- Манлайлал, багшийн залгамж халааны бодлогын хэрэгжилтийг үнэлж сайжруулах
- Багшийн хөгжлийн бодлогыг олон улсын сайн туршлагатай уялдуулах

Үнэлгээний шалгуур

1. Үйлдвэрлэлд суурилсан багшийн хөгжлийн хэрэгжилтийн түвшин
2. Салбарын мэргэжилтэн, инженерийн сургалтад оролцооны тогтвортой байдал
3. Багшийн мэргэжлийн ур чадвар, заах арга зүйг сайжруулах
4. Манлайлал, менежментийн чадамжийн өсөлт
5. Ажил олгогч, суралцагчийн сэтгэл ханамж

Хэмжих аргачлал

1. Багшийн үйлдвэрлэлийн дадлагын тайлан, гэрээ, батламж
2. Багшийн чадамжийн үнэлгээ, сертификат, сургалтын бүртгэл
3. Зочин багшийн хичээлийн бүртгэл
4. Ажил олгогч, суралцагчийн санал асуулгын үр дүнгийн тайлан
5. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын тайлан

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 3. СУРАЛЦАГЧ ТӨВТЭЙ СУРГАЛТЫН ОРЧИН, ДЭД БҮТЦИЙН ШИНЭЧЛЭЛ

Олон зориулалттай, орчин үеийн лаборатори, дадлагын баазыг хөгжүүлэх, дижитал болон виртуал сургалтын орчныг өргөжүүлэн, аюулгүй, хүртээмжтэй, суралцахад ээлтэй орчин бүрдүүлэх

Зорилт 3.1. Олон зориулалттай, орчин үеийн лаборатори, дадлагын баазыг хөгжүүлэх

Политехник коллежийн сургалтын чанарыг бодит ур чадварт суурилсан болгох зорилгоор сургалтын лаборатори, дадлагын баазыг орчин үеийн техник, технологид нийцүүлэн шинэчилж, олон зориулалтаар ашиглах боломжтой болгон хөгжүүлнэ. Лаборатори, дадлагын орчин нь үйлдвэрлэлийн бодит ажлын байртай ойролцоо, хөдөлмөрийн аюулгүй байдал, стандарт шаардлагыг хангасан байна.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Лаборатори, дадлагын баазын шинэчлэл**
   - Салбарын стандарт, технологийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах
   - Олон мэргэжил, модульд ашиглах уян хатан зохион байгуулалт бүхий лаборатори байгуулах
2. **Үйлдвэрлэлд ойртсон сургалтын орчин бүрдүүлэх**
   - Үйлдвэрлэл–сургалтын хамтарсан дадлагын баазыг хөгжүүлэх
   - Бодит тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн кейсэд суурилсан сургалт явуулах
3. **Ашиглалт, менежментийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх**
   - Лабораторийн ашиглалтын хуваарь, нэгдсэн менежмент нэвтрүүлэх
   - Засвар, шинэчлэл, аюулгүй ажиллагааны тогтолцоог сайжруулах

Зорилт 3.2. Дижитал болон виртуал сургалтын орчныг өргөжүүлэх

Суралцагчийн уян хатан суралцах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор цахим, танхим хосолсон, виртуал сургалтын орчныг үе шаттайгаар хөгжүүлж, сургалтын агуулга, арга зүйг дижитал технологид тулгуурлан шинэчилнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Дижитал сургалтын дэд бүтэц хөгжүүлэх**

- Сургалт удирдлагын систем (LMS), цахим платформыг бүрэн ашиглалтад оруулах
- Дижитал контент, интерактив сургалтын материалыг нэмэгдүүлэх

2. **Виртуал, симуляцид суурилсан сургалтыг нэвтрүүлэх**
   - VR/AR, симуляцийн лаборатори, программ ашиглах
   - Аюултай, өндөр өртөг бүхий дадлагыг виртуал орчинд гүйцэтгэх боломж бүрдүүлэх
3. **Багш, суралцагчийн дижитал ур чадварыг дэмжих**
   - Цахим сургалтын арга зүй, хэрэглээний сургалт зохион байгуулах
   - Дижитал сургалтын чанарын стандарт, үнэлгээний шалгуур нэвтрүүлэх

Зорилт 3.3. Аюулгүй, хүртээмжтэй, суралцахад ээлтэй орчныг бүрдүүлэх

Суралцагч бүрийн хэрэгцээ, ялгаатай байдлыг харгалзан аюулгүй байдал, тэгш хүртээмж, эрүүл ахуй, сэтгэл зүйн таатай орчинд суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Хөдөлмөрийн болон сургалтын аюулгүй байдлыг хангах**
   - ХАБ,ЭА, галын аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт мөрдүүлэх
   - Аюулгүй ажиллагааны сургалт, дадлагыг тогтмолжуулах
2. **Хүртээмжтэй сургалтын орчин бүрдүүлэх**
   - Тусгай хэрэгцээт суралцагчдад зориулсан дэд бүтэц, тоноглолыг сайжруулах
   - Цахим болон танхимын сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх
3. **Суралцахад ээлтэй, дэмжих орчин бүрдүүлэх**
   - Номын сан, бие даалтын орчин, хамтран суралцах орон зайг өргөжүүлэх
   - Сэтгэл зүйн зөвлөгөө, суралцагчийн дэмжих үйлчилгээг сайжруулах

Зорилт 3.4. Ногоон, тогтвортой, инновацад суурилсан сургалтын орчныг хөгжүүлэх

Байгаль орчинд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, инновацыг дэмжсэн ногоон сургалтын орчин бүрдүүлж, суралцагчдад тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, хандлагыг төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Ногоон дэд бүтэц, эрчим хүчний хэмнэлт**
   - Эрчим хүч, ус, хог хаягдлын хэмнэлттэй шийдэл нэвтрүүлэх
   - Ногоон технологи, сургалтын жишиг орчин бүрдүүлэх
2. **Инновац, туршилт–бүтээлч орчин хөгжүүлэх**
   - Maker space, innovation lab байгуулах

- Суралцагчийн бүтээлч санаа, туршилтыг дэмжих

3. **Тогтвортой хөгжлийн боловсролыг орчинтой уялдуулах**
   - Ногоон ур чадвар, тогтвортой хөгжлийн агуулгыг сургалтын орчинд шингээх
   - Суралцагчийн оролцоотой ногоон санаачилгыг дэмжих

2030 он хүртэл хүрэх түвшин

Үзүүлэлт, KPI	2030 он хүртэл хүрэх түвшин
Орчин үеийн лаборатори, дадлагын баазтай мэргэжлийн хувь	100%
Олон зориулалттай лабораторийн тоо	15+
Виртуал/симуляцид суурилсан сургалттай хичээлийн хувь	60%+
Цахим, танхим хосолсон хэлбэрээр явагдсан хичээлийн хувь	70%+
Аюулгүй байдлын стандарт хангасан сургалтын орчны хувь	100%
Ногоон, инновацын сургалтын орчны тоо	5+
Суралцагчийн сургалтын орчны талаарх сэтгэл ханамж	90%+

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2025–2026 он

- Лаборатори, дадлагын баазын суурь үнэлгээ, шинэчлэлийн төлөвлөгөө боловсруулах
- Цахим сургалтын платформ, дижитал дэд бүтцийг бэхжүүлэх
- Аюулгүй байдал, хүртээмжийн стандарт боловсруулах, батлах

2027–2028 он

- Олон зориулалттай лаборатори, симуляцийн орчныг үе шаттай байгуулах
- VR/AR, виртуал сургалтыг сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх
- Суралцагчийн дэмжлэг, суралцах орчныг өргөжүүлэх

2029–2030 он

- Сургалтын орчны шинэчлэлийг бүрэн хэрэгжүүлж, чанарын иж бүрэн үнэлгээ хийх
- Ногоон, инновацад суурилсан сургалтын орчныг бий болгох
- Дижитал болон танхимын сургалтын уялдааг бүрэн хангах

Үнэлгээний шалгуур

1. Лаборатори, дадлагын орчны шинэчлэл, ашиглалтын түвшин

2. Дижитал, виртуал сургалтын хүртээмж, чанар
3. Аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт
4. Хүртээмж, суралцах орчны таатай байдал
5. Суралцагчийн сэтгэл ханамж, сургалтын үр дүн

Хэмжих аргачлал

1. Дэд бүтцийн аудит, техникийн үнэлгээ
2. Лаборатори, дадлагын баазын ашиглалтын тайлан
3. Цахим сургалтын системийн статистик мэдээ, тайлан
4. Суралцагч, багшийн сэтгэл ханамжийн үнэлгээ
5. ХАБ,ЭА, хүртээмжийн хяналт, шалгалтын үр дүн

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 4. АЖ ҮЙЛДВЭР, ДОТООД ГАДААДЫН ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН СУРГАЛТ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Ажил олгогчийн оролцоотой хөтөлбөр, дадлагын тогтолцоог хөгжүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих механизм бүрдүүлэх, үйлдвэрлэл–сургалт–ажлын байрны уялдааг хангах

Зорилт 4.1. Ажил олгогчийн оролцоотой сургалтын хөтөлбөр, дадлагын тогтолцоог хөгжүүлэх

Сургалтын агуулгыг хөдөлмөрийн зах зээлийн бодит хэрэгцээтэй нийцүүлэх зорилгоор ажил олгогчийн идэвхтэй оролцоонд суурилсан сургалт, үйлдвэрлэлийн дадлагын тогтолцоог хөгжүүлнэ. Ажил олгогч нь сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх бүхий л шатанд оролцдог түнш байхаар төлөвлөнө.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Ажил олгогчийн оролцоотой хөтөлбөрийн загвар хэрэгжүүлэх**
   - Хөтөлбөр боловсруулах, шинэчлэхэд ажил олгогчийн төлөөллийг оролцуулах
   - Ажлын байрны стандарт, ур чадварын шаардлагыг сургалтын агуулгад тусгах
2. **Үйлдвэрлэлд суурилсан дадлагын тогтолцоог сайжруулах**
   - Урт болон богино хугацааны үйлдвэрлэлийн дадлагын хөтөлбөр хэрэгжүүлэх
   - Дадлагын удирдагчаар салбарын мэргэжилтэн ажиллуулах
3. **Дадлагын чанар, үр дүнг үнэлэх тогтолцоо бүрдүүлэх**
   - Дадлагын гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, рубрик нэвтрүүлэх
   - Ажил олгогчийн үнэлгээг суралцагчийн үнэлгээтэй уялдуулах

Зорилт 4.2. Үйлдвэрлэл–сургалт–ажлын байрны уялдааг хангах түншлэлийн тогтолцоог бэхжүүлэх

Сургалтын байгууллага, ажил олгогч, орон нутгийн байгууллагын хамтын ажиллагааг системтэй хөгжүүлж, сургалтаас ажлын байранд шилжих тасралтгүй гинжин холбоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Стратегийн түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх**
   - Дотоод гадаадын болон салбарын тэргүүлэгч байгууллагуудтай урт хугацааны түншлэл байгуулах
   - Орон нутгийн болон бүсийн хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан хамтын ажиллагаа хөгжүүлэх
2. **Сургалт–ажлын байрны шилжилтийн механизмыг бүрдүүлэх**
   - Дадлага → ажлын байр руу шилжих “career pathway” загвар хэрэгжүүлэх
   - Ажил олгогчийн захиалгат сургалтыг хөгжүүлэх
3. **Хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд суурилсан төлөвлөлт хийх**
   - Салбарын эрэлт хэрэгцээ, ур чадварын прогнозыг ашиглах
   - Сургалтын багтаамж, чиглэлийг зах зээлийн мэдээлэлтэй уялдуулах

Зорилт 4.3. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц механизм бүрдүүлэх

Төгсөгчдийг хөдөлмөрийн зах зээлд амжилттай шилжихэд дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа, зуучлал, зөвлөгөө, дагалдах үйлчилгээний цогц тогтолцоог хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Карьер хөгжлийн үйлчилгээ, дэмжлэгийг бэхжүүлэх**
   - Карьер зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах
   - CV, ярилцлагын ур чадвар, ажил хайх чадварыг хөгжүүлэх
2. **Ажил олгогч–төгсөгчийг холбох механизм бий болгох**
   - Ажил олгогчийн өдөрлөг, карьер экспо, онлайн платформ ашиглах
   - Төгсөгч–ажил олгогчийн мэдээллийн сан бүрдүүлэх
3. **Өөрийгөө ажлын байраар хангах, гарааны бизнесийг дэмжих**
   - Стартап, бичил бизнесийн сургалт, зөвлөгөө үзүүлэх
   - Инновац, бүтээлч санаачилгыг дэмжих орчин бүрдүүлэх

Зорилт 4.4. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн ур дүнг тогтмол хянах, сайжруулах

Сургалтын чанар, зах зээлийн нийцлийг бодит мэдээлэлд тулгуурлан сайжруулах зорилгоор төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээлэл, ур дүнг системтэйгээр цуглуулах, дүн шинжилгээ хийх тогтолцоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн мониторингийн тогтолцоо бий болгох**
   - 6 сар, 12 сарын дараах хөдөлмөр эрхлэлтийн судалгаа хийх
   - Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
2. **Ажил олгогчийн сэтгэл ханамж, санал хүсэлтийг ашиглах**
   - Төгсөгчийн ур чадварын талаар ажил олгогчоос тогтмол санал асуулга авах
   - Судалгааны үр дүнд тулгуурлан хөтөлбөрөө сайжруулах
3. **Мэдээлэлд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих**
   - Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтийг KPI-тэй уялдуулах
   - Сургалтын бодлого, төлөвлөлтөд ашиглах

2030 он хүртэл хүрэх түвшин

Үзүүлэлт, KPI	2030 он хүртэл хүрэх түвшин
Ажил олгогч оролцсон сургалтын хөтөлбөрийн хувь	100%
Үйлдвэрлэлд суурилсан дадлагад хамрагдсан суралцагчийн хувь	90%+
Урт хугацааны стратегийн түнш байгууллагын тоо	30+
Дадлага → ажлын байранд шилжсэн төгсөгчдийн хувь	50%+
Төгсөгчдийн мэргэжлээрээ ажилласан хувь (6 сарын дотор)	90%+
Карьер хөгжлийн үйлчилгээ авсан төгсөгчдийн хувь	100%
Ажил олгогчийн төгсөгчид өгсөн сэтгэл ханамж	90%+

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2025–2026 он

- Ажил олгогчийн оролцоотой сургалт, дадлагын журам боловсруулах
- Стратегийн түншлэл, хамтын ажиллагааны гэрээ байгуулах
- Карьер хөгжлийн үйлчилгээний бүтэц, чадавхыг бэхжүүлэх

2027–2028 он

- Захиалгат сургалт, дадлага–ажлын байрны уялдааг өргөжүүлэх
- Карьер платформ, төгсөгчийн мэдээллийн сан бүрдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлтийн дунд шатны үнэлгээ хийх

2029–2030 он

- Түншлэл, хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог тогтворжуулах
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн иж бүрэн үнэлгээ хийх
- Үр дүнд суурилсан сайжруулалтыг хэрэгжүүлэх

Үнэлгээний шалгуур

1. Ажил олгогчийн сургалтад оролцооны түвшин, чанар
2. Дадлагын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүн
3. Үйлдвэрлэл–сургалт–ажлын байрны уялдаа
4. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт
5. Ажил олгогч, төгсөгчийн сэтгэл ханамж

Хэмжих аргачлал

1. Хөтөлбөр, дадлагын гэрээ, баримт бичгийн аудит
2. Дадлагын гүйцэтгэл, ажил олгогчийн үнэлгээ
3. Төгсөгч, ажил олгогчийн судалгаа
4. Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн сан, тайлан
5. Карьер үйлчилгээний бүртгэл, статистик

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ 5. УДИРДЛАГА, ЗАСАГЛАЛ, ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Өгөгдөл, KPI-д суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг сайжруулах, ил тод, хариуцлагатай, үр ашигтай засаглалыг төлөвшүүлэх

Зорилт 5.1. Өгөгдөл, KPI-д суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх

Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг бодит мэдээлэлд тулгуурлан удирдах зорилгоор өгөгдөл, гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт (KPI)-д суурилсан удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ. Шийдвэр гаргалт нь нотолгоо, өгөгдөлд суурилсан, хэмжигдэхүйц, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Стратегийн KPI тогтолцоо бүрдүүлэх**
   - Байгууллага, нэгж, хөтөлбөрийн түвшний KPI-ийг уялдуулан тодорхойлох
   - KPI-ийг стратегийн зорилт, зорилготой уялдуулах
2. **Өгөгдлийн нэгдсэн сан, дашбоард хөгжүүлэх**
   - Сургалт, хүний нөөц, санхүү, хөдөлмөр эрхлэлт, чанарын өгөгдлийг нэгтгэх
   - Удирдлагын түвшинд ашиглах дижитал дашбоард нэвтрүүлэх
3. **Өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг хэвшүүлэх**
   - Тайлан, дүн шинжилгээнд суурилсан удирдлагын соёлыг төлөвшүүлэх
   - Мэдээллийн чанар, найдвартай байдлыг хангах

Зорилт 5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ний тогтолцооны үр нөлөөг сайжруулах

Стратеги, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг тогтмол үнэлж, сайжруулах зорилгоор үр дүнд суурилсан, тасралтгүй хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Үр дүнд суурилсан ХШҮ-ний загвар хэрэгжүүлэх**
   - Зорилго–зорилт–KPI–үр дүнгийн логик уялдааг хангах
   - Дунд болон эцсийн үнэлгээний тогтолцоо нэвтрүүлэх
2. **ХШҮ-ний чадавхыг бэхжүүлэх**
   - Алба нэгж, ажилтнуудын ХШҮ-ний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх
   - Үнэлгээний арга зүй, стандартчиллыг сайжруулах
3. **Үнэлгээний үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах**
   - Үнэлгээний дүгнэлтийг бодлого, төлөвлөлтөд тусгах
   - Сайжруулалтын арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх

Зорилт 5.3. Ил тод, хариуцлагатай, үр ашигтай засаглалыг төлөвшүүлэх

Байгууллагын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлага, ёс зүй, үр ашгийг хангах замаар сайн засаглалын тогтолцоог төлөвшүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Ил тод байдлыг нэмэгдүүлэх**
   - Стратеги, гүйцэтгэл, санхүүгийн мэдээллийг нээлттэй мэдээлэх
   - Оролцогч талуудтай тогтмол харилцах механизм бүрдүүлэх
2. **Хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх**
   - Албан тушаал, нэгжийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох
   - Гүйцэтгэлд суурилсан хариуцлагын тогтолцоо хэрэгжүүлэх
3. **Үр ашигтай засаглал, дотоод хяналтыг сайжруулах**
   - Процессын оновчлол, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлэх
   - Ёс зүй, авлигаас ангид орчныг төлөвшүүлэх

Зорилт 5.4. Чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлэх

Сургалтын чанар, үйлчилгээний тасралтгүй сайжруулалтыг хангах зорилгоор дотоод болон гадаад чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлнэ.

Хэрэгжүүлэх стратеги

1. **Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгох**
   - Хөтөлбөр, сургалт, үйлчилгээний чанарын шалгуур тогтоох
   - Чанарын дотоод аудит, өөрийн үнэлгээг тогтмолжуулах
2. **Гадаад үнэлгээ, магадлан итгэмжлэлд бэлтгэх**
   - Үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн шаардлагад нийцүүлэх
   - Үнэлгээний дүгнэлтэд суурилсан сайжруулалт хийх
3. **Чанарын соёлыг байгууллагын түвшинд төлөвшүүлэх**

- Багш, ажилтан, суралцагчийн оролцоотой чанарын соёлыг дэмжих
- Чанарын инновац, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

2030 он хүртэл хүрэх түвшин

Үзүүлэлт, KPI	2030 он хүртэл хүрэх түвшин
Стратегийн KPI бүрэн хэрэгжсэн байдал	100%
KPI-д суурилсан дашбоард ашиглаж буй нэгжийн хувь	100%
ХШҮ-ний тайлан, үнэлгээ жил бүр хийгдсэн байдал	100%
Үнэлгээний үр дүнд суурилсан сайжруулалтын хэрэгжилт	90%+
Ил тод мэдээлсэн стратеги, гүйцэтгэлийн тайлангийн хувь	100%
Дотоод чанарын аудитад хамрагдсан хөтөлбөрийн хувь	100%
Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн эзлэх хувь	80%+
Оролцогч талуудын засаглалд өгсөн сэтгэл ханамж	90%+

Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

2025–2026 он

- KPI, ХШҮ, чанарын баталгаажуулалтын нэгдсэн журам боловсруулах
- Өгөгдлийн сан, удирдлагын дашбоардын суурь систем нэвтрүүлэх
- Дотоод чанарын баталгаажуулалтын бүтэц, баг бүрдүүлэх

2027–2028 он

- KPI-д суурилсан удирдлагыг бүх түвшинд хэрэгжүүлэх
- ХШҮ-ний дүнд шатны үнэлгээ, сайжруулалт хийх
- Магадлан итгэмжлэлд бэлтгэх ажлыг эрчимжүүлэх

2029–2030 он

- Удирдлага, засаглал, чанарын тогтолцоог тогтворжуулах
- Стратегийн хэрэгжилтийн иж бүрэн үнэлгээ хийх
- Үр дүнд суурилсан засаглалын загварыг бататгах

Үнэлгээний шалгуур

1. Өгөгдөл, KPI-д суурилсан удирдлагын хэрэгжилт
2. ХШҮ-ний чанар, бодит үр нөлөө
3. Ил тод байдал, хариуцлагын түвшин
4. Чанарын баталгаажуулалтын үр дүн
5. Оролцогч талуудын сэтгэл ханамж

Хэмжих аргачлал

1. KPI дашбоард, гүйцэтгэлийн тайлан
2. ХШҮ-ний тайлан, үнэлгээний дүгнэлт
3. Дотоод болон гадаад аудитын тайлан
4. Магадлан итгэмжлэлийн материал, дүгнэлт
5. Оролцогч талуудын санал асуулга

ПК-2030 стратеги төлөвлөгөөний замын зураглал /Roadmap/

Тэргүүлэх чиглэл	Зорилт	KPI	2025 суурь түвшин	2026	2027	2028	2029	2030 зорилт	Эрсдэл	Шийдэл (Mitigation)	Хариуцагч нэгж	Тайлагнах давтамж
1. Сургалтын чанар	1.1	Чадамжид суурилсан шаталсан бүтэцтэй хөтөлбөрийн эзлэх хувь		80%	90%	95%	100%	100%	Шинэчлэл удаашрах	Салбарын оролцоог нэмэгдүүлэх, Яамны батлагдсан стандарт, ШУТИС-ийн дүрэм журам	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр
	1.2	Дадлага/төсөлд суурилсан хичээлийн хувь		55%	65%	70%	70%	70%+	Дадлагын бааз дутмаг	Түншлэл өргөжүүлэх	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр
	1.3	Гүйцэтгэлд суурилсан үнэлгээтэй хичээлийн хувь		65%	75%	90%	100%	100%	Багшийн бэлэн бус байдал	Сургалт, рубрик	Сургалт, чанарын алба	Жил бүр
2. Багш, ХН	2.1	Үйлдвэрлэлд суурилсан дадлагад хамрагдсан багш		50%	60%	70%	80%	80%+	Ачаалал их	Урамшуулал, гэрээ	Хүний нөөц, тэнхимүүд	Жил бүр
	2.2	Зочин/хамтарсан багштай хичээлийн хувь		40%	45%	50%	50%	50%+	Салбарын оролцоо сул	Уян хатан гэрээ	Захиргаа, тэнхимүүд	Жил бүр
	2.3	Манлайллын сургалтад хамрагдсан удирдлага		75%	85%	95%	100%	100%	Цагийн хомсдол	Онлайн сургалт	Захиргаа	Жил бүр
3. Сургалтын орчин	3.1	Сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон лабораторитой мэргэжлийн хувь		80%	85%	90%	100%	100%	Санхүүжилт	Үе шаттай хөрөнгө оруулалт	Захиргаа	Жил бүр

	3.2	Виртуал/симуляц ашигладаг хичээлийн хувь		40%	50%	55%	60%	60%+	Тоног төхөөрөмж	Программ худалдан авах	Захиргаа, тэнхимүүд	Хагас жил
	3.3	Цахим/холимог сургалтын хичээлийн хувь		50%	60%	65%	70%	70%+	Багшийн ур чадвар	Сургалт	Захиргаа, тэнхимүүд	Жил бүр
	3.4	Суралцагчийн орчны сэтгэл ханамж		85%	88%	90%	90%	90%+	Орчны ачаалал	Сайжруулалт	Сургалт, чанарын алба	Жил бүр
4. Аж үйлдвэр, хөдөлмөр эрхлэлт	4.1	Ажил олгогч оролцсон хөтөлбөрийн хувь		80%	90%	95%	100%	100%	Түншлэл сул	MoU нэмэх	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр
	4.2	Үйлдвэрлэлд суурилсан дадлагад хамрагдсан суралцагч		85%	90%	93%	95%	95%+	Дадлагын байр хомс	Түншлэл	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр
	4.3	Дадлага → ажлын байр шилжилт		60%	65%	68%	70%	70%+	Ажлын байр цөөн	Захиалгат сургалт	Захиргаа	Жил бүр
	4.4	Төгсөгчдийн мэргэжлээрээ ажилласан хувь		80%	85%	88%	90%	90%+	Зах зээлийн хэлбэлзэл	Карьер дэмжлэг	Захиргаа	Жил бүр
5. Удирдлага, засаглал	5.1	KPI-д суурилсан удирдлагын хэрэгжилт		75%	85%	95%	100%	100%	Өгөгдөл дутмаг	Dashboard нэвтрүүлэх	Захиргаа	Жил бүр
	5.2	KPI дашбоард ашиглаж буй нэгжийн хувь		65%	75%	85%	100%	100%	Системийн мэдлэг	Сургалт	Захиргаа	Жил бүр
	5.3	Дотоод чанарын аудитад хамрагдсан хөтөлбөр		80%	90%	95%	100%	100%	Ачаалал	Төлөвлөлт	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр
	5.4	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хувь		65%	70%	75%	80%	80%+	Бэлтгэл дутмаг	Зөвлөх баг	Сургалт, чанарын алба, тэнхимүүд	Жил бүр

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зургаан зарчим

Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг баримтлахыг зөвлөж байна.

Зарчим 1. Алсын хараагаа хуваалцах
ШУТИС ПК-2030 алсын хараг боловсруулахдаа зөвхөн харуулах биш, харин оролцогч талуудтай хуваалцахад чиглэх ёстой. Алсын хараа нь маргаашийн бодит байдал боловч өнөөдөр хараахан биелээгүй байдаг. Алсын хараагаа хуваалцах нь үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх манлайллын эх үүсвэр болохоос гадна эерэг уур амьсгал бий болгох гол хүч болдог.

Зарчим 2. Тууштай бодлого
Ажлын үр дүн, амжилт нь ганц хоёрхон өдрийн дотор бий болохгүй, хэрэгжүүлэх бүхий л хугацааны турш гаргасан шаргуу хичээл зүтгэл, тууштай бодлогын үр дүн байх болно.

Зарчим 3. Оролцогч талуудыг оролцуулах
Стратеги төлөвлөгөөний амжилт нь “гайхалтай стратеги төлөвлөгөө”-өөр тодорхойлогдохгүй, харин оролцогч талуудын хүлээж буй үр дүн байх болно. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ оролцогч талуудыг санал хүсэлтийн механизм болгон оролцуулах нь амжилтад хүрэхэд чухал ач холбогдолтой.

Зарчим 4. Маргаашийг төлөвлө
Стратеги төлөвлөгөөг өнөөдөрт биш маргаашид чиглэж хийх ёстой. Жинхэнэ инновац одоохондоо бий болоогүй байж болно. Бид аж үйлдвэрийн 4-р хувьсгалын шинэ боломжуудыг анхаарч үзэх хэрэгтэй.

Зарчим 5. Дасан зохицох чадвартай багш нар ба оюутнууд
Сургуулийн багш нар болон оюутнуудыг шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадвартай болгох арга замыг хайж олох хэрэгтэй.

Зарчим 6. Хурдтай өөрчлөлтөд тохирсон бодлого, зохицуулалт
Хурдтай өөрчлөлтөд тохирсон сургуулийн бодлого, дүрэм журмыг урьдчилан бэлтгэсэн байх ёстой. Өсөлтийн менежмент гэдэг нь энгийнээр хэлбэл цаг хугацааны менежмент юм.

Политехник коллежийн онцлог шинж

Политехник коллеж нь мэргэжлийн болон техникийн боловсролыг үйлдвэрлэлтэй уялдуулан, суралцагчийг ажлын байранд шууд гарахад бэлэн болгоход чиглэсэн дараах онцлог давуу талуудтай.

1. Практик давамгайлсан сургалт
- Сургалтын 60–70% нь дадлага
- Бодит тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн орчинд ажиллах чадвар эзэмшинэ
- “Сураад биш – хийж сурна” зарчим

2. Шаталсан, уян хатан бүтэц
- Certificate → Diploma → Bachelor (Applied) хэлбэрийн шатлал
- Ажил хийж байхдаа суралцах, дахин суралцах боломж
- Нас, туршлага үл харгалзсан lifelong learning чиглэл

3. Ажил олгогчтой нягт холбоотой
- Dual education буюу (хосмог сургалт)
- Үйлдвэрлэл дээрх дадлага, захиалгат сургалт
- Хөтөлбөр боловсруулах, үнэлгээ хийхэд ажил олгогчид оролцоно

4. Чадамжид суурилсан сургалт (Competency-based)
- Онол мэдэхээс илүү ямар ажил гүйцэтгэж чадах вэ? гэдгийг үнэлнэ
- Чадамж бүрд тодорхой:
  - гүйцэтгэх ажил
  - шалгуур
  - нотолгоо (portfolio, бодит даалгавар)

5. Хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн үр дүн
- Төгсөгчид:
  - шууд ажилд орох
  - үйлдвэрлэлд дасан зохицох хугацаа богино
- Эрэлттэй мэргэжил олгодог

6. Дижитал ба “ногоон” ур чадвар
- Industry 4.0: автоматжуулалт, IoT, CNC, CAD/CAM
- Эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөгжил, ногоон технологи
- Дижитал бичиг үсэг, аюулгүй ажиллагаа

7. Үр дүнд суурилсан үнэлгээ
- Шалгалтаас илүү:
  - бодит төслийн ажил
  - кейс
  - багийн төсөл
- Ажил олгогчийн үнэлгээ, ажлын байран дээрх шалгалт


8. Багшийн онцлог
- Үйлдвэрлэлд ажилласан туршлагатай
- Инженер, технологич, мастер багш
- Сургалт + үйлдвэрлэлийн хосолсон туршлага

Стратеги төлөвлөгөө боловсруулсан дэлгэрэнгүй мэдээлэл

Төлөвлөлтийн дараалал	
Р0 Бэлтгэл ажил	Р0-1 Даалгаврын зорилго, хамрах хүрээг тодорхойлох
	Р0-2 Мастер төлөвлөгөөг боловсруулах багийг байгуулах
	Р0-3 Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах
	Р0-4 Эхлэлийн тайлан
Р1 Одоогийн бодит байдлын шинжилгээ	Р1-1 Гадаад орчны шинжилгээ
	Р1-2 Дотоод чадамжийн шинжилгээ
Р2 Алсын хараа ба стратеги	Р2-1 Алсын хараа
	Р2-2 Стратеги шийдлүүдийг судлах
	Р2-3 Стратегийг гаргах
Р3 Зорилтуудыг тодорхойлох	Р3-1 Стратегийг хэрэгжүүлэх зорилтуудыг санал болгох
	Р3-2 Зорилтуудыг тодорхойлох
	Р3-3 Гол зорилтуудыг тодорхойлох
	Р3-3 Гол зорилтуудыг эрэмбэлэх
Р4 Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Р4-1 Зорилтуудыг хэрэгжүүлэх хугацаа, төсөв, гүйцэтгэлийн үзүүлэлтүүд бүхий төлөвлөгөө гаргах
	Р4-2 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх замын зураглал (Roadmap) гаргах
Р5 Эцсийн шат	Р5-1 Эцсийн тайлан

Гол зорилтууд

Стратеги төлөвлөгөө боловсруулах багийн хэлэлцүүлгийн үр дүнд 5 стратегийн тэргүүлэх чиглэл 20 гол зорилтыг тодорхойлсон. Стратегийн модыг дараах зурагт үзүүлсэн байдлаар зурагласан болно.



ШУТИС ПК-ийн 2030 стратеги төлөвлөгөөний ерөнхий тогтолцоог дээрх байдлаар зурагласан. ПК-ийн стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

[1]. Achievements and Challenges of World-Class Research University (WCU) Development Project (OR2012-05-20-18), Research Report, KEDI, 2012. Pp. 1- 19.

[2]. Annual Report. 2018-2019 School Year, SICT, MUST, 2019.

[3]. Asa Olsson and Lynn Meek (Ed.), “Effectiveness of Research and Innovation Management at Policy and Institutional Levels,” IHERD, OECD, January 08, 2016.

[4]. C.K. Min, C.G. Lee Lee, “The effective policy alternatives for promotion of research universities,” Policy Research, STEPI, December 2000, pp. 1-146.

[5]. Faustin Kamuzora, “A Practical Guide on Taking University-Industry Linkages to Higher Heights in Africa,” Joint AAU-AUCC Workshop, Accra, June 29-30, 2012.

[6]. Jamil Salmi, The Challenge of Establishing World-Class Universities, The World Bank, 2009.

[7]. Joseph Kadoma Byaruhanga, “Strengthening Higher Education Stakeholder Relations Through Intellectual Property Rights in African Universities,” Policy Brief, No. 3, CIDA, January, 2013.

[8]. M. Kim, O.K. Cha, S.J. Park, D.H. Jang and H.J. Vhu, “A Study for Graduate Education Innovation in the Age of Fourth Industrial Revolution: Focusing on Research-Oriented Universities,” Research Report (RR2020-11), KEDI, 2020.

[9]. Master Plan on Education Sector Development of Mongolia, Phase II (2016-2021).

[10]. Mongolian Sustainable Development Concept 2030 (Mongolian Sustainable Development Concept 2030), 2016.

[11]. MUST-2030 Strategic Planning, MUST, 2025.

[12]. S.J. Cheon, “Development process and direction of development of researchoriented universities.” Science and Technology Policy 21(2), STEPI, 2011, pp. 27- 41.

[13]. S.J. Cheon, S.W. Hong, B.K. Kim, S.K. Jung amd S.J. Hong, “Planning for fostering researchoriented universities, Policy Research, Korea Research Foundation, May 2005.